



Б.БАЯСГАЛАН
ХСИС-ийн
Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн Харуул
хамгаалалтын
тэнхимийн эрхлэгч,
хурандаа

ХОРИХ БАЙГУУЛЛАГААС ОРГОСОН ЯЛТАН, ХОРИГДОГЧИЙГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГААНД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Хураангуй: Хорих байгууллагаас оргосон ялтан, хоригдогчийг ил хэлбэрээр эрэн сурвалжлах ажиллагааны дараалал, цаашид анхаарах асуудлын талаар судлаачийн байр, сууринаас өөрийн бодлыг энэхүү өгүүлэлээр илэрхийлэхийг оролдсон болно.

Түлхүүр үг: Оргох, эрэн сурвалжлах, хорих анги, хорих байгууллага, хамтын ажиллагаа, ялтан, хоригдогч, ил арга хэмжээ, ердийн ажиллагаа, эрэн сурвалжлах лавлагаа, интерпол.

Монгол Улсын эрүүгийн ялын оногдуулалтын илрэл нь шүүх эрх мэдлийн хүрээнд явагдаж, эрүүгийн ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагаагаар дамжин хэрэгждэг билээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төрийн

эрүүгийн ялын бодлогын хэрэгжилтийг хангаж, гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг нийгмээс тусгаарлаж иргэдийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэ чиг үүргийг хэрэгжүүлэх явцад ялтан, хоригдогсдын зүгээс хорих анги, баривчлах, цагдан хорих байрны харуул хамгаалалтын ажилтны хариуцлаггүй байдал, ялтны ажлын байр, үйлдвэрлэлийн онцлог байдлыг ашиглан хамгаалалтын инженер-техникийн хэрэгслийг эвдэх, зориулалтын саад, төхөөрөмжийг давж туулах, харуул хамгаалалтын албан хаагчийн амь бие, эрүүл мэндэд халдах арга замаар ганцаар болон бүлэглэн оргох гэмт хэрэг үйлдсээр байна.

Хэдийгээр нийгэм, эдийн засгийн хөгжлийг дагаад хорих байгууллагын харуул хамгаалалт нь үйл ажиллагаандаа орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглаж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг гаралтыг бууруулж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар Шүүхийн шийдвэрг гүйцэтгэх ерөнхий газрын хэмжээнд: 2012 онд-18, 2013 онд-10, 2014 онд-10, 2015 онд-3, 2016 онд-2 болж оргох гэмт хэрэг үйлдэгдэж буурсан¹ үзүүлэлт гарч байгаа нь сайшаалтай хэдий ч бүрэн таслан зогсоож чадахгүй байна.

¹ “Тогтоол гүйцэтгэх газрын 2016 оны тайлан”-аас

Академич С.Нарангэрэл
Оргох /англ. *escare, flight*, ор. *побег*/-1. сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс хууль бусаар зайлсхийж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг зогсооход чиглэгдсэн үйлдэл; 2. МУ-ын ЭХ-ийн 261 дүгээр зүйлд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан шүүх, цагдан хорих, хорих ангийг дур зоргоороо орхисон шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг.² гэж тодорхойлсон байна. Харин судлаач миний өөрийн зүгээс **Хорих байгууллагаас оргох гэдэг нь** хорих анги, цагдан хорих болон баривчлах ял эдлүүлэх байрны амьдралын болон үйлдвэрийн бүсээс харуул хамгаалалтын албан хаагчдын сонор сэрэмжгүй байдлыг ашиглах, харуул хамгаалалтын техник тоног төхөөрөмжийг эвдэж сүйтгэх, албан хаагчийн амь биед хүч хэрэглэн халдан довтлох зэрэг аргаар хорих ял эдлэхээс зайлсхийх санаа бодлоо гүйцэтгэж байгааг ойлгоно. Өөрөөр хэлбэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаанаас санаатайгаар

зайлсийх үйлдлийг оргох³ гэж тодорхойлж болох юм.

Оргох гэмт хэрэг нь нийгмийн хор аюулын хувьд онц хүнд байдаг нь дараахь байдлаар илэрдэг.

Үүнд:

1. Оргосон этгээд дахин гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр

2. Хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулдаг

3. Нийгмийг айдаст автуулдаг

4. Оргох явцдаа харуул хамгаалалтын техник тоног төхөөрөмжийг эвдэж сүйтгэх, албан хаагчийн амь биед хүч хэрэглэн халдан хүнд хор уршиг учруулах зэрэг хор уршгийг учруулдаг байна.⁴

Иймээс нийгэм, иргэдийн аюулгүй байдлыг хангахын тулд хорих байгууллагаас оргосон этгээдийг эрэн сурвалжлан, цаг алдахгүй баривчлах нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үндсэн үүрэг билээ.

Оргох гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрэн сурвалжлах ажиллагаа гэдэг нь Хорих байгууллагаас сэжигтэн, яллагдагч, ялтан оргосон тохиолдолд хууль

² С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” 2011 он 349 дүгээр тал

³ Б.Баясгалан “Хорих байгууллагаас оргосон этгээдийг гүйцэтгэх ажлын шугмаар эрэн сурвалжлах ажиллагааг боловсронгуй болгох нь” 2010 он 5 дахь тал

⁴ С.Жанцан “Эрүүгийн эрх зүй” 2005 он 152 дахь тал

тогтоомжийн хүрээнд оргодлыг эрж олох, хайх, илрүүлэн баривчлах эрх бүхий байгууллагууд, ажилтнуудын бие даасан үйл ажиллагаа юм.

Эрэн сурвалжлах ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гүйцэтгэх тангуулын ажлын нэг хэсэг болгон авч үзэх бүрэн үндэслэлтэй билээ. Гүйцэтгэх ажлын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад “...урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдгээрийн урьд үйлдсэн болон хорих анги дотор гарсан хэргийг илрүүлэх, түүнчлэн оргосон хоригдлыг баривчлах...”⁵, “...хуульд заасан үндэслэлээр гүйцэтгэх ажил явуулах;...”⁶ гэж хуульчилж өгсөн.

Эрэн сурвалжлах ажиллагаа нь өөрийн онол, арга барил, зүйн тогтолтой бөгөөд эрэн сурвалжлах ажиллагааны тодорхойлолт, түүний зорилго, зохицуулах зүйлийг эрдэмтэн судлаач нар судалгааны ажил, ном зохиолдоо тодорхойлжээ. Академич С.Нарангэрэл: Эрэн сурвалжлах гэдэг нь мөрдөлт ба шүүхээс оргосон этгээдийг илрүүлэх, байгаа газрыг нь тогтоох, ял эдлэхээс зайлсхийсэн шүүгдэгч буюу хорих газраас оргосон ялтныг олоход

чиглэсэн төрийн эрх хэмжээ бүхий /хэрэг бүртгэх мөрдөн байцаах зэрэг/ байгууллагын үйл ажиллагаа юм. Хэрэв гэмт хэрэг үйлдсэн этгээд тодорхой бус бол түүнийг тогтоох арга хэмжээ эрэн сурвалжлах ойлголтонд хамаарахгүй бөгөөд гэмт хэргийг мөрдөх ба илрүүлэх агуулгатай болно⁷ гэжээ.

Хорих байгууллагаас оргосон оргодол этгээдийг эрэн сурвалжлах ажиллагаа гэдэг нь: Хорих анги, баривчлах ял эдлүүлэх болон цагдан хорих төв /байр/-наас оргосон этгээдийг орогнож, нуугдах боломжийг илрүүлж, олж баривчлахад чиглэсэн Гүйцэтгэх ажлын тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актад тулгуурласан гүйцэтгэх ажлын нууц далд болон ил арга хэмжээнүүдийн нэгдсэн тогтолцоо юм. Тиймээс судлаачийн зүгээс илээр эрэн сурвалжлах ажиллагаа явуулахад анхаарах зарим асуудлыг хөндөхийг зорисон билээ. Ил буюу ердийн арга хэмжээ ч гэсэн мэдээлэгчийг нууцлах шаардлагатай байдаг. Зарим судлаач энэ талаар дурдсан байна.Тухайлбал: Эрэн сурвалжлах ердийн ажиллагаа. Үүнд гүйцэтгэх тагнуулын хүч, арга хэрэгслийг ашиглахгүйгээр гүйцэтгэж буй арга

⁵ “Гүйцэтгэх ажлын тухай хууль” 9.1.4 дүгээр зүйл

⁶ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” 134.1.1 дүгээр зүйл

⁷ С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” 2008 он 623 дэх тал

хэмжээнүүдийг ойлгоно. Гэвч ердийн ажиллагаа нь объектоос нууцлах шаардлагатай болдог. Өөрөөр хэлбэл ердийн эрэн сурвалжлах ажиллагаа ч тодорхой хэмжээгээр нууцлалыг шаарддаг байна.⁸

Ил арга хэмжээнд хорих анги, байгууллагаас орголт гарсан анхны мэдээг хүлээж авмагц доорхи арга хэмжээг авна. Үүнд:

- Оргодол этгээдийн ул мөрийг илрүүлэх, бэхжүүлж авч, хэргийн газрыг хамгаалалтанд авна.

- Оргосон, цаг хугацааг тодорхойлно.

- Оргодлын тоог тогтооно.

- Зэвсэглэсэн эсэхийг тодорхойлно.

- Унаажсан эсэхийг тодорхойлон тухайн газар орон, үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан төв зам, шалган нэвтрүүлэх цэг, тээврийн хэрэгслийн зогсоолуудад отолт, боолт, хийх, олон нийтийн газруудыг шалгах, **орогнож нуугдаж болох газруудыг самнах** зэргээр ил арга хэмжээг шуурхай зохион байгуулна. **Удирлага зохион байгуулалтын хүрээнд:**

- Оргодол этгээдийн талаархи эрэн сурвалжлах лавлагаа гаргана.

Эрэн сурвалжлах лавлагаанд доорхи мэдээллүүд багтана. 3 талаас харуулсан фото зураг, биеийн байцаалт, гадна төрх байдал, содон шинж тэмдэг, оршин сууж байсан гэрийн хаяг, оргох үедээ өмсөж явсан хувцас, мэргэжил, авьяас чадвар, гэр бүл, садан төрөл, найз нөхөд, гэмт хэрэг хамтран үйлдэгсдийн оршин суух хаяг, урьд өмнө нь ажиллаж байсан албан газар, бусад орогнож болох газрууд гэх мэтийг тодорхойлно.

- Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах төлөвлөгөө боловсруулна.

Төлөвлөгөөнд эрэн сурвалжлах ажиллагаа явуулах маршрут, хүрээ, тойрог, оролцох хүн хүчний тооцоо, зэвсэг, тусгай хэрэгсэл, ямар тээврийн хэрэгсэл, уналага, хэдий хугацаанд заагдсан газар оргодол этгээгээдээс түрүүлж хүрч отолт хаалт хийх, эрэн сурвалжлах ажлын шатахуун хүнсэнд зарцуулах зардал, мөрдөн мөшгөх, самналт хийх газар зэргийг тодорхой тусгаж өгнө.

- Эрэн сурвалжлах бүлгүүдийг томилж дэвшүүлсэн таамаглалын дагуу орогнож нуугдаж болох газар, орон байрыг шалгана.

- Орон нутгийн цагдаагийн байгууллагад мэдэгдэж олшруулсан эрэн сурвалжлах лавлагааг хүргүүлэх.

⁸ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал” сэтгүүл 2015 он УБ, 02, 03 дугаар 27 дахь тал

- Эрүүлжүүлэх байр болон албадан саатуулах газруудыг шалгах.

- Оргодол этгээдийн талаар иргэд, байгууллагад зарлаж анхааруулах. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдэгдэж оргодлын талаархи мэдээллийг худалдан авах ажиллагаануудыг шуурхай зохион байгуулна.

Эрэн сурвалжлах лавлагааг үнэн зөв гаргахад хорих анги, байгууллагын тоо бүртгэлийн алба, нийгэм, сэтгэл зүйн алба чухал үүргийг гүйцэтгэнэ. Тухайн оргодол хорих анги, цагдан хорих байр /төв/-анд хувиарлагдан ирэхэд тоо бүртгэлийн алба уг ялтны талаархи дэлгэрэнгүй мэдээлэл, биеийн байцаалт, содон шинж тэмдэгийг бүртгэн хувийн хэрэг нээдэг, энэхүү хувийн хэрэг материал нь тухайн этгээд ял эдэлж, албадан саатуулагдаж байх хугацаандаа оргосон тохиолдолд эрэн сурвалжлах лавлагаанд орох мэдээллийн эх сурвалж нь болж өгдөг. Иймээс ялтны хувийн хэрэгт байвал зохих материалыг баяжуулж байх нь эрэн сурвалжлах ажиллагаанд чухал ач холбогдолтой. Цагдан хоригдож, ял эдэлж байгаа хүмүүст нийгэм, сэтгэл зүйн алба үйлчилгээ үзүүлдэг. Үйлчилгээ үзүүлэх явцдаа тухайн хүний хувийн байдал, сэтгэл зүйн байдлыг тодорхойлсон байдаг тул зарим

хувь хүний шинжтэй мэдээллүүд авагдсан байдаг.

Эрэн сурвалжлах ажиллагааг цар хүрээгээр нь:

- Орон нутагт зохион явуулах ажиллагаа

- Улсын хэмжээнд зохион явуулах ажиллагаа

- Олон улсын хэмжээнд зохион явуулах ажиллагаа гэж ангилна.

Оргодол этгээдийг орон нутгийн хэмжээнд эрэн сурвалжлах ажиллагаа:

Аймаг, орон нутгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж байгаа хорих анги, баривчлах ял эдлүүлэх болон цагдан хорих байрнаас оргодол оргосон тохиолдолд хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны даргын тушаалаар батлагдсан шуурхай бүлэг, эрэн сурвалжлах бүлэг эрэн сурвалжлах ажлыг тухайн нутаг дэвсгэрт бүсчлэн шуурхай зохион байгуулна. Энэ төрлийн эрэн сурвалжлах ажиллагаанд оролцож байгаа ажилтан тухайн газар орноо сайн мэддэг, нутгийн иргэдийг таньдаг байх нь эрэн сурвалжлах ажлын үр дүнд нөлөөлдөг. Орон нутгийн эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулахдаа тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хууль хяналтын байгууллагатай урьдчилан төлөвлөсний дагуу ажиллаж, дэмжлэг авахын зэрэгцээ

оршин суугаа иргэдийн мэдээ, мэдээллийг өргөнөөр ашигладаг байна. Харин тухайн оргодол этгээдийн оршин сууж, ажиллаж, амьдарч байсан орон нутагт эрэн сурвалжлах ажиллагааг явуулахад нутгийн иргэд оргодол этгээдийг нууж хайцайлах, худал мэдээлэх, эрэн сурвалжлах ажиллагааг төөрөгдүүлэх гэх мэт хүндрэл бэрхшээлүүд гардаг онцлогтойг анхаарах хэрэгтэй.

Оргодол этгээдийг улс орны хэмжээнд эрэн сурвалжлах ажиллагаа:

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулагдах ба орон нутгийн эрэн сурвалжлах ажиллагаа үндсэн зорилгодоо хүрээгүй, тухайн этгээд нийгэм иргэдэд аюул учруулж болзошгүй, эрэн сурвалжлах арга хэмжээг цаашид өргөтгөн улс орон даяар зохион байгуулах шаардлагатай болсон үед Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар өөрийн хүч, хэрэгслээр эрэн сурвалжлах ажиллагааг улс орны хэмжээнд зохион байгуулна. Өөрөөр хэлбэл системн хэмжээнд эрэн сурвалжлах ажиллагаанд хамрагдаж оролцоно гэсэн үг юм. Оргодол этгээдийг улсын хэмжээнд эрэн сурвалжлаж байгаа тохиолдолд Эрүүгийн цагдаагийн газрын 6 дугаар хэлтсээр

дамжуулан улсын хэмжээний эрэн сурвалжлалт зарладаг.

Улс орны хэмжээгээр зохион байгуулж буй эрэн сурвалжлах ажиллагаанд хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа нэн чухал юм.

Оргодол этгээдийг олон улсын хэмжээнд эрэн сурвалжлах ажиллагаа:

Улс төр, цэргийн, шашин шүтлэг ба арьсны өнгөөр ялгаварлах шинжтэй гэмт хэргийн учир ялтан дээр Интерполын үндэсний төв товчоогоор дамжуулан олон улсын эрэн сурвалжлалтыг зарлахгүй. Хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт яллагдаж байгаа яллагдагч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан бол Интерполын үндэсний төв товчоогоор дамжуулан олон улсын эрэн сурвалжлалтыг зарлана.

Хорих ялаар шийтгэгдсэн нөхцөлд эрүүгийн ял шийтгэл эдлэхээс зайлсхийгчид ба оргосон ялтныг Интерполын үндэсний төв товчоогоор дамжуулан олон улсын хэмжээний эрэн сурвалжлалтаар зарлана. Хэрэв аль нэг улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу нийгэмд аюултай үйлдэлдээ эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй хэрэгт яллагдаж байгаа буюу ялагдсан хүн дээр тэр улсын нутаг дэвсгэрт эрэн сурвалжлалтын арга хэмжээ

зохиох шаардлага гарсан тохиолдолд Интерполын шугамаар олон улсын хэмжээний эрэн сурвалжлалт зохион байгуулахыг татгалзаж болно.

Яллагдагч ба ялтан дээр Интерполын үндэсний төв товчоогоор дамжуулан олон улсын хэмжээний эрэн сурвалжлалт зарлахад заавал байх нөхцөл бол эрэн сурвалжлагдаж байгаа хүн цагдан хорихоор таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан байх ёстой.

Оргож нуугдсан яллагдагч ба ялтнуудыг олон улсын хэмжээнд эрэн сурвалжлахаар зарлахын хамт эрэн сурвалжлалтыг санаачлагч байгууллагаас тогтсон журмын дагуу Монгол Улсын Хил хамгаалах ерөнхий газарт эрэн сурвалжлагдаж байгаа этгээдүүдийг хилийн байцаан өнгөрүүлэх газруудаар улсын хил нэвтрэх эсэхэд хяналт тогтоож, уг этгээдийг хил дээр саатуулах, баривчлах ажиллагаа зохион байгуулах тухай хүсэлтийг явуулна.

Интерполын Үндэсний төв товчоогоор дамжуулан ялтныг олон улсын хэмжээнд эрэн сурвалжлахаар зарлах нь ялтныг олон улсын хэмжээнд эрэн сурвалжлах үндэслэл бүхий тогтоолын үндсэн дээр хийгдэнэ.

Ялтныг олон улсын хэмжээнд эрэн сурвалжлахаар зарлах

тухай тогтоол нь эрэн сурвалжлагдаж байгаа ялтны оршин байгаа газрыг тогтоох зорилгоор Интерполын шугамаар олон улсын эрэн сурвалжлалтыг зарлан явуулах үндэс болно.

Ялтныг баривчлах ба шилжүүлэн өгөх зорилготой олон улсын эрэн сурвалжлалтыг Интерполын үндэсний төв товчоогоор дамжуулан зарлана.

Ялтныг шилжүүлэн өгөх тухай албан ёсны хүсэлтийг явуулахын өмнө тэднийг баривчлах, эрэлт шаардлагын хамт Монгол Улсын Ерөнхий прокурорын газраас Интерполын шугамаар гадаад улсуудын эрх мэдэл бүхий байгууллагад хандаж өгөх даалгавар нь яллагдагч, ялтныг баривчлах ба шилжүүлэн өгөх зорилго бүхий олон улсын эрэн сурвалжлалт зарлах үндэслэл болно.⁹

Дүгнэлт:

Монгол Улс нийгэм, эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжиж буй сүүлийн жилүүдэд гэмт хэргийн тоон үзүүлэлт өсөхийн хэрээр гэмт үйлдлийн арга нарийсч илүү хор аюултайгаар өөрчлөгдөн, улам зохион байгуулалттай, нийгэм эдийн засаг, улс төр, бизнесийн салбар түүнчлэн эрүүгийн гэмт

⁹ М.Цогтоо ТЕГ-ын сөрөх тагнуулын үйл ажиллагааны үндэс

хэрэгтнүүдийг хамарсан шинэ өнгө аяс бүхий бүлэглэлүүд үүсч эрүүгийн гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрсээр байна. Тиймээс хорих байгууллагаас ялтан, хоригдогсдыг зохион байгуулалттай орлуулах гэмт хэрэг гарах магадлал өндөр байгааг анхаарч үзэн хорих байгууллагын зүгээс авч хэрэгжүүлэх сөрөг арга хэмжээнүүдийг авах бэтгэлтэй байх.

Даяаршиж өнөө үед эрэн сурвалжлах ажиллагаа нь зөвхөн нэг улсын асуудал бус олон улсын хэмжээнд хууль хяналтын байгууллагуудын анхаарлыг татсан асуудал бөгөөд эрэн сурвалжлах ажиллагаанд олон улсын байгууллага Интерпол тэдгээрийн салбар байгууллагууд оролцдог болоод байна. Хууль хяналтын байгууллагаас оргодол этгээд нуугдахын тулд хилийн чанадад янз бүрийн арга хэрэглэн гарах, гадаад улс оронд оргонох явдал түгээмэл болсныг анхааралдаа авч цаашдын ажиллагаандаа тусган ажиллах хэрэгтэй болжээ судлаачийн байр сууринаас үзлээ.